



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-16
<hr/>	
1.“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газраас 2026.05.01- ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	10-11
2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	11
3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нарын 4 гишүүн 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	12-13
4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 33 гишүүн 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	13
5.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	13-14
6.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	15-16

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 02-ны өдөр /Мягмар гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 53.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 07 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, О.Алтангэрэл, Н.Батсүмбэрэл, Б.Бейсен, Х.Болормаа, Г.Ганбаатар, Д.Ганмаа, М.Ганхүлэг, Г.Дамдинням, Х.Жангабыл, Д.Жаргалсайхан, Ц.Идэрбат, П.Мөнхтулга, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, А.Ундраа, Ч.Ундрэм, Б.Уянга, Д.Үүрийнтуяа, Б.Хосбаяр, Б.Хэрлэн, Да.Цогтбаатар, Ө.Шижир, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Ж.Баясгалан, Ц.Даваасүрэн, Ж.Дэлгэрсайхан, Ч.Лодойсамбуу, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: М.Бадамсүрэн, А.Ганбаатар, Ж.Ганбаатар;

Хоцорсон: О.Амгаланбаатар-02 минут, Т.Аубакир-04 минут, Ж.Батжаргал-09 минут, Ж.Батсуурь-02 минут, Б.Батцэцэг-16 минут, Э.Батшугар-04 минут, Ж.Бат-Эрдэнэ-10 минут, Б.Баярбаатар-07 минут, Ж.Баярмаа-10 минут, Х.Булгантуяа-04 минут, Л.Гантөмөр-07 минут, Б.Жавхлан-10 минут, Ж.Золжаргал-33 минут, С.Зулпхар-10 минут, М.Мандхай-13 минут, Л.Мөнхбаатар-22 минут, Б.Найдалаа-09 минут, Ч.Номин-04 минут, Н.Номтойбаяр-13 минут, Б.Пунсалмаа-02 минут, Ц.Туваан-09 минут, Д.Цогтбаатар-03 минут, Ж.Чинбүрэн-07 минут, Б.Энхбаяр-08 минут, С.Эрдэнэбат-12 минут, Р.Эрдэнэбүрэн-01 минут.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Хууль зүйн байнгын хороонд;

2.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хороонд;

3.Засгийн газар 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд;

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа нарын 46 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./14:17/

Нэг. “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газраас 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн гурав дахь хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 44
Бүгд: 90

51.1 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 42
Бүгд: 91

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Батбаяр, С.Зулпхар, Э.Болормаа, Р.Сэддорж нарыг дэмжсэнээр тооцож, 59.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нарын 4 гишүүн 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: 1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 31
Бүгд: 92

66.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

С.Бямбацогт: 2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 27
Бүгд: 92

70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 24
Бүгд: 92

73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 33 гишүүн 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 51
Бүгд: 92
44.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул “Хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов./14.32/

Уг асуудлыг 12 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: 1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын

хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 26
Бүгд: 92
71.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

С.Бямбацогт: 2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 20
Бүгд: 92
78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 34
Бүгд: 92
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Бусад.Булган аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 1981 оны төгсөгчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 32 минут үргэлжилж, 126 гишүүнээс 93 гишүүн хүрэлцэн ирж, 73.8 хувийн ирцтэйгээр 14 цаг 39 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 07 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурлын 2026 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдааны ирц ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Ирц хүрсэн учраас чуулганы нэгдсэн хуралдаанаа эхлүүлье. Нээснийг мэдэгдье. Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж байгаа. Одоо удахгүй дуусах гэж байна. Гишүүд ороод ирэх байхаа.

Өнөөдрийн чуулганы хуралдааны ирцэд одоо эхний 5 гишүүнийг танилцуулъя. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн өглөө 9 цагт ирцдээ орсон байна. Отгоншарын Батнайрамдал гишүүн 10 цаг 21 минутад, Тогмидын Доржханд гишүүн 11 цаг 32 минутад, Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн 11 цаг 38 минутад, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн 11 цаг 40 минутад эртэч гишүүд болж ирцдээ оржээ. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн чуулганаар дараах 5 асуудлыг хэлэлцэнэ.

Өнгөрсөн баасан гаргийн чуулганы хуралдаанаас хэлэлцэж амжаагүй санал хураагдахаар үлдсэн асуудлууд байгаа.

Нэгдүгээрт нь, Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын Тогтоолын төслийн 3 дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ. Засгийн газар 2026 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн 6 сарын 1-ний дотор одоо эцэслэн батлах хуулийн хугацаатай. Төлөвлөгөө батлахгүй бол бас дахиад Засгийн газарт төлөвлөгөө дахиж өргөн барьж дахиж одоо Улсын Их Хурал хэлэлцэх ийм одоо аргагүй нөхцөл байдалд орно.

Хоёрдугаарт нь, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын гишүүд өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

Гуравдугаарт нь, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх, эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ. Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал нарын гишүүд 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх.

Дөрөвдүгээрт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцээрийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их

Хурлын гишүүн Бадамсүрэн нарын 33 гишүүн 25 оны 11 сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Тавдугаарт нь, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн 2025 оны 12 сарын 17-нд,

Зургаад нь, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар 2026 оны 5 сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх хийгдэнэ.

Санал хураалтуудтай байгаа. Гишүүдийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Төрийн байгуулалтын байнгын хороо сүүлийн асуудлаа хэлэлцэж байна. Одоо ингээд ороод ирэх байх ТББХ-ны гишүүд.

Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

1.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг нарын 37 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд,

2.Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа нарын 37 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд,

3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд,

4.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа нарын 46 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсан. Та бүхэнд мэдээлье ээ.

Гишүүд хэлэлцэх асуудалдаа оръё.

**“Монгол Улсын 2027 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газраас 2026.05.01-ний өдөр
өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/**

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 3 дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ ээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр 2026 оны 6 дугаар сарын 2-ны өдөр хүртэл завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна.

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Улсын Их хурал дахь МАН-ын бүлгийн даргаас үг хэлэх үү та? Үг хэлэхгүй гэж байна. Одоо “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе ээ.

Санал хураалтад 90 гишүүн ирцэд орсон байна. Одоогоор бэлэн болсон 65 гишүүн байна. 67 гишүүн байна.

Санал хураалтад бэлэн болоогүй гишүүдийг бэлэн болгохыг хүсэж байна. Чинбүрэн гишүүн та санал хураалт бэлтгэж амжаагүй байх шиг байна. Баярбаатар гишүүн байсан даа сая. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт. 66 гишүүн бүртгэлд орсон байна. 24 гишүүн бүртгэлд ороогүй байгаа. Энэ одоо нэр гарч байгаа. 24 гишүүн Булгантуяа, Болормаа, Сэддорж, Цогтгэрэл, Чойжилсүрэн, Эрдэнэбат гээд гишүүд өөр хэн хэн байна. Чуулганы танхимдаа хүрэлцэн ирье ээ. Ирцэд орчхоод санал хураалтад татгалзсан гарч байгаа гишүүд байна уу? Танхимд сууж байгаа гишүүдээс. Алга байна тиймээ.

Санал хураалт явуулъя.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 46 гишүүн буюу 51.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа.

Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсэгт талархал илэрхийлье. Сая бол бас гишүүд нэлээн бас шүүмжлэл хэлж байсан. Засгийн газар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулахдаа Улсын Их Хурлын гишүүдээс тодорхой саналуудыг авна гэсэн боловч саналаа өгсөн гишүүдийн саналыг тусгаагүй байсан. Тийм болохоор цаашдаа бас Засгийн газраас бас энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхдээ Улсын Их Хурлын гишүүдийн саналыг авах саналыг тусгах тал дээр бас онц онцгой анхаарах ёстой. Жилийн төсөв боловсруулахдаа бас энэ гишүүдийн гаргасан саналуудыг бас хүндэтгэлтэй хандаж оруулж ирэхийг бас Энхбаяр сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд танд бас чиглэл өгье өө. Та бас анхаарах ёстой шүү.

14.21 цаг

Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Тэмүүжин гишүүн. Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс 2026 оны 5 сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдааны үеэр дараах хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгээс нэг өдрийн завсарлага авсан байгаа. Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дэгтэй холбоотой асуудлууд дээр. Завсарлагын хугацаа дууссан гээд та микрофондоо хэлчих үү. Тэмүүжин гишүүнд микрофон өгье.

Х.Тэмүүжин: Завсарлагын хугацаа дууссан. Улсын Их Хурлын тухай хуулиудыг та бүхэн бүгдээрээ дэмжээд өгөөрэй.

С.Бямбацогт: Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Санал хураалтдаа бэлтгэе. 65 гишүүн бэлэн болсон байна. 26 гишүүн бэлэн болж амжаагүй байна.

Одоо санал хураалт явуулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Санал хураалтдаа бэлдсэн байгаа. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Баярлалаа.

Санал хураалтад Эрдэнэболд гишүүн дэмжсэнээр, Батбаяр гишүүн дэмжсэнээр, Зулпхар гишүүнийг дэмжсэнээр тооцъё. Ингээд 53 гишүүн. Болормаа гишүүн дэмжсэнээр 54 гишүүн дэмжлээ. Сэддорж гишүүн дэмжсэнээр авъя. Харин Цаашдаа дэг нь энэ зохицуулагдаж байгаа. Байнга одоо ингээд санал хураалтад хэн дэмжсэн, хэн дэмжээгүй нь тогтвортой гарна. Ингэж гүйгээд өнгөрөхгүй тийм тэгж бас нэг жоохон ил тод нээлттэй болохгүй бол ингээд буруу мэдээлэл яваад байдаг. Гишүүд маань бас өөрсдөө хариуцлагатай оролцоод саналаа өгчих юм бол өөрийнх нь өгсөн саналаас эсрэг мэдээлэл гарахгүй шүү дээ. Энэ гишүүдийн хувь гишүүдийн өөрсдийн хариуцлагатай холбоотой асуудал бас.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

14.27 цаг

Гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нарын 4 гишүүн 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх, эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлт хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос, 61 гишүүн буюу 66.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос, 65 гишүүн буюу 70.7 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй, аан дэмжигдлээ. Уучлаарай.

3.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос, 68 гишүүн буюу 73.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдөр нэгтгэчихнэ. Ажлын хэсэг гарна. Бүлгүүдээс нэрс ирэх ёстой. Бүлгүүдээс ирсэн нэрсийн дагуу 15 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулаад өмнө нь санаачилсан бүх гишүүдийн санаачилсан хуулиудыг нэгтгээд хэлэлцэнэ. Дараагийн асуудалдаа орёе оо.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 33 гишүүн, 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлт хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төсөл үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Нэлээн олон гишүүн бэлдээгүй байна шүү.

Санал хураалт явуулъя.

Монгол Улсын нөгөө дэмжээгүй саналыг дэмжье гээд нэг ойлгомжгүй томъёоллоор санал хураадгийг болиулах, Бадамсүрэн нарын гишүүдийн хуулийн төсөл.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.14-д санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй. Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол батлагдсанд тооцно. Үүний дагуу энийг буцаалаа.

14.36 цаг

Дараагийн асуудалдаа орёе.

Тав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгээ үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. 67 гишүүн бэлэн болсон байна.

Санал хураалт явуулъя.

Энэ сая Мөнхсоёл гишүүний ярьдаг нөгөө санал хураалтад гарсан дүнг ил нээлттэй тавьдаг, тогтоож тавьдаг болох ийм санал шүү. Нөгөө ил тод нээлттэй байх ямар гишүүд нь дэмжиж байгаа ямар гишүүд нь дэмжээгүйг олон нийт мэдэх эрхтэй. Энэ мэдэх эрхийг хангах ийм одоо агуулга бүхий хуулийн төсөл байгаа.

Санал хураалт явуулъя.

Бүх асуудал дээр нээлттэй хэлэлцэж байгаа бүх асуудал дээр.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 71.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос, 72 гишүүн буюу 78.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Зургаа.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар 2026.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлт хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Цогтбаатар манай Даваагийн Цогтбаатар гишүүний санаачилсан төсвийн гүйцэтгэл хэлэлцэх үед асуулт асууж, үг хэлэх гишүүдийн цаг минутыг хугацааг уртасгах ийм санал байгаа. Хэлэлцүүлэг одоо илүү чанартай явуулъя гэсэн агуулгаар санал гаргасан. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос, 58 гишүүн буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцогчдын олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Зочин танилцуулъя. Булган аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр 10 жилийн сургуулийн 1981 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амьдарч амьдралд нь эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаж байна. Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан саяын Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулиудыг өмнөх, одоо хэлэлцэгдэн дэмжигдсэн хуулиудтай нэгтгээд 1 ажлын хэсэг байгуулаад энэ хаврын чуулгандаа хэлэлцэж батлах Улсын Их Хурлын үйл ажиллагааг одоо илүү иргэддээ ил тод, нээлттэй, иргэдийн оролцоотой, Их Хурлын гишүүдийн одоо ажлыг бас одоо илүү сайжруулж, сахилга бат, хариуцлага, ёс зүйг дээдлэх ийм агуулга бүхий одоо хуулиуд гишүүд санаачилсан. Энэ санаачилсан

гишүүдийн хуулийг одоо хэлэлцээд баталчих юм бол Улсын Их Хурлын бас үйл ажиллагаа иргэд олон нийтийн дунд одоо нэр хүнд сайжирч Улсын Их Хурлын үйл ажиллагаа улам илүү зохион байгуулалттай сайн болж одоо бас төрд итгэх парламентад итгэх ард иргэдийн итгэл дээшлэх болно оо.

Тэгээд энэ гишүүд маань бас анхааралтай, ажлын хэсэг маань бас одоо хариуцлагатай ажиллахыг хүсье ээ. Чуулган нэгдсэн хуралдаан дууссан тул өнөөдрийн чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

14.39 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*